



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

“Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг
даатгагч нарт хуваарилах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 26.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ ЧАДААГҮЙ ЖОЛООЧ НАРЫГ ДААТГАГЧ НАРТ ХУВААРИЛАХ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь “Даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах”-тай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР.Даатгалын тохиолдол байнга гаргадаг үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах

2.1.Даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын компани авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, жолоочийг даатгахаас татгалзсан нөхцөлд тухайн этгээд уг даатгалын компанид даатгалын гэрээний хугацааг нэг удаа сунгах санал тавих эрхтэй бөгөөд даатгагч татгалзах эрхгүй байна.

2.2.Авто тээврийн хэрэгслийн жолоочийг даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын байгууллага албан ёсоор татгалзсан нөхцөлд тухайн этгээд Санхүүгийн зохицуулах хороонд ~~/Даатгалын газар/~~ хүсэлт гаргана. Хүсэлтийг хавсралт 1 маягтын дагуу гаргана.

/Энэ хэсгийн “Даатгалын газар”-г Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор хассан/

2.3.Жолоочийг даатгалд хамруулахаас татгалзсан даатгалын компани нь энэ тухай мэдэгдлээ хавсралт 2 маягтын дагуу гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ.

2.4.Ажлын алба нь даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилахад даатгалын компаниудад тэгш хуваарилах зарчмыг баримтлах бөгөөд тайлант хугацаанд хохирол нөхөлтийн түвшин хамгийн бага тооцогдсон компаниас эхэлж сонголт хийнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

2.5.Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба нь сонголт хийсэн компанид хавсралт 3 маягтаар мэдэгдэл хүргүүлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

ГУРАВ.Хяналт, хариуцлага

3.1.Санхүүгийн зохицуулах хороо энэхүү журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд хуваарилагдсан жолоочийг даатгахаас татгалзсан болон даатгуулагчийг хүлээж аваагүй даатгагчид Даатгалын тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах журам”-ын 1 дүгээр хавсралт

**АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЛ ӨМЧЛӨГЧ,
ЖОЛООЧИЙГ ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД
ДААТГУУЛАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газар

Засгийн газрын IY байр, Бага тойруу-3, Улаанбаатар-46

Монгол Улс

Өргөдөл гаргагч:

Хувь хүн, хуулийн этгээд /доогуур нь зурах/

/Иргэн, хуулийн этгээдийн нэр/.....нь даатгалд хамрагдах хүсэлтэй хэдий ч даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын компани даатгахаас татгалзсан тул Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах журам”-ын дагуу даатгалын компанид хуваарилж өгнө үү.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

.....
/гарын үсэг/

.....
/овог, нэр /

Регистрийн дугаар:
Улсын бүртгэлийн дугаар, Иргэний үнэмлэхийн дугаар:
Хаяг:
Тээврийн хэрэгслийн улсын дугаар:
Тээврийн хэрэгслийн марк:.....
Даатгахаас татгалзсан даатгагчийн нэр:
Өмнөх гэрээний хугацаанд гаргасан даатгалын тохиолдлын тоо:
Даатгалын нийт нөхөн төлбөрийн хэмжээ:

“Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах журам”-ын 2 дугаар хавсралт

ДААТГАХААС ТАТГАЛЗСАН ТУХАЙ КОМПАНИЙН МЭДЭГДЭЛ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газар

Засгийн газрын IY байр, Бага тойруу-3, Улаанбаатар-46

Монгол Улс

Даатгалын компанийн нэр:

Манай компани нь /иргэн, хуулийн этгээд/-г даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгахаас татгалзаж байгаа тул мэдэгдлийг хүлээн авна уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....
/гарын үсэг/

.....
/овог, нэр /

Даатгуулагч этгээдийн регистрийн дугаар:
Улсын бүртгэлийн дугаар, Иргэний үнэмлэхийн дугаар:
Хаяг:
Тээврийн хэрэгслийн улсын дугаар:
Тээврийн хэрэгслийн марк:.....
Даатгахаас татгалзсан даатгагчийн нэр:
Өмнөх гэрээний хугацаанд гаргасан даатгалын тохиолдлын тоо:
Даатгалын нийт нөхөн төлбөрийн хэмжээ:

